


**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС 2019 ОНЫ 2 ДУГААР УЛИРАЛД БАТЛАН ГАРГАСАН ЗАХИРАМЖИЙН ЦАГААНДЭЛГЭР СУМАНД
ХОЛБОГДОЛТОЙ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТ**

2019.06.04

№	Захирамж ийн дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Заалтын дугаар	Заалт	Хэрэгжилт	Хувь
17	А/156	Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготной тэмцэх ажлыг зохион байгуулах тухай 2019.4.22	20	<p>Хоёр. Уг ажиллагаанд шаардагдах улсын төсвөөс хуваарилагдсан зардал дээр сум бүр санхүүгийн дэмжлэг нэмж үзүүлэх, орон нутагт зохион байгуулах ажлын хэсгийг байгуулах, голомт бүхий малчин өрхөөс тус бүр 1 малчныг ажиллуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p> <p>/Сайнцагаан, Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэн, Цагаандэлгэр, Луус, Сайхан-овоо, Эрдэнэдалай, Говь-Угтаал, Гурвансайхан/</p>	<p>Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготной тэмцэх ажлыг 2019 оны 04 дугаар сарын 22-ны өдөр аймгийн ХХААГазрын даргатай байгуулсан гэрээний дагуу сумын Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн А/33 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулан сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд үлийн цагаан оготно тархсан талбайд тандалтыг нарийвчлан хийж байршлыг тогтоон хортон мэрэгчтэй тэмцэх талбайг сонгон тухайн бүс нутагт байгаа 4 багийн 71 малчдыг оролцуулан 5,7 тн бактержуулсан будааг 2,8 мянган га бэлчээрийн талбайд цацаж бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготной тэмцэх ажлыг зохион байгууллаа.</p> 	100

			22	Тав. Үлийн цагаан оготной тэмцэх ажлыг төсөвт зардалд багтаан технологийн хугацаанд чанартай, үр дүнтэй хийж тайлагнахыг холбогдох сумдын засаг дарга нарт даалгасугай. <i>/Сайнцагаан, Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэн, Цагаандэлгэр, Луус, Сайхан-овоо, Эрдэнэдалай, Говь-Угтаал, Гурвансайхан /</i>	Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготной тэмцэх ажлыг 2100000 төгрөгийн төсөвт зардалд багтаан зохион байгуулж ажлын тайлан мэдээг гаргаж холбогдох газарт хүргүүлж ажиллалаа.	100
ХЭРЭГЖИЛТ						100

ХЭРЭГЖИЛТИЙГ БИЧСЭН: ХАА-Н ТАСГИЙН МЭРГЭЖИЛТЭН

Ц.УНДРАХБАЯР

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН: ЗДТГ-ЫН ДАРГА

З.СОЛОНГО